



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/Б5

Пионер толгой

Авто тээврийн хэрэгслийн  
шинэчилсэн бүртгэл тооллогыг зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, “Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь заалт, Зам тээврийн хөгжлийн яамны сайд, Сангийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/57/48 хамтарсан тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/157 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийг журмын дагуу үзлэг, тооллогод бүрэн хамруулах арга хэмжээг 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 20-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2.Дээрх ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга :	Р.Гантулга	Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүдэд:	Л.Дуламдорж	Хэсгийн төлөөлөгч, Ахмад
	Б.Лувсанширээв	Цэнгэл 1 дүгээр багийн Засаг дарга
	Д.Мөнхчулуун	Давааны ам 2 дугаар багийн Засаг дарга
	Д.Болд-Аюуш	Буга 3 дугаар багийн Засаг дарга
	Б.Баттулга	Хөвийн ам 4 дүгээр багийн Засаг дарга
	Ч.Батцэцэг	Пионер толгой 5 дугаар багийн Засаг дарга

**642201251**

Х.Бат-Эрдэнэ                      Сумын цагдаа, Дэд ахлагч  
Нарийн бичгийн дарга:    М.Саруулбуян                      Татварын Улсын байцаагч

3.Арга хэмжээний үеэр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

4.Авто тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл тооллогыг явуулах, татвар хураалтын ажлыг сумын хэмжээнд зохион байгуулахтай холбогдон гарах нийт 1246600 (Нэг сая хоёр зуун дөчин зургаан мянга зургаан зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын дарга (Р.Гантулга), нягтлан бодогч (Б.Дэлгэрдалай) нарт зөвшөөрсүгэй.

5.Тооллогын арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, ажлын тайлан мэдээг гаргаж 2023 оны 05 дугаар сарын 23-ны дотор холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэхийг комиссын дарга (Р.Гантулга), нарийн бичгийн дарга (М.Саруулбуян) нарт үүрэг болгосугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Сүглэгмаа)-д даалгасугай.

ДАРГА



Б.ГАНТУЛГА

Сумын Засаг даргын 2022 оны  
04 сарын 04-ны өдрийн ... А./35-  
дугаар захирамжийн хавсралт

АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ШИНЭЧИЛСЭН БҮРТГЭЛ,  
ТООЛЛОГО ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	2	3	4
1.	Авто тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэлийн ажлын талаар мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулах	4/03-5/20	Комиссын гишүүд
2.	Тооллогод хамрагдах тээврийн хэрэгслийн судалгааг аймгийн Авто тээврийн газраас хүлээн авч, татварын өрийн үлдэгдлийг гаргаж, тоологч нарт багаар хуваарилан өгөх	4/03-4/05	Татварын Улсын байцаагч М.Саруулбуян
3.	Тээврийн хэрэгслээ зарсан боловч албан ёсны шилжүүлэг хийлгээгүй, цаашид ашиглах боломжгүй болсон боловч албан ёсны хасалт хийлгээгүй, олон жилийн хуримтлагдсан татварын өртэй, торгуультай тээврийн хэрэгслийн эзэмшигчтэй биечлэн болон утсаар холбогдож тухайн тээврийн хэрэгсэл дээрх өрийн мэдээллийг өгч, үүссэн өрийг барагдуулан ажиллах	4/5-5/20	Татварын Улсын байцаагч, Багийн Засаг дарга
4.	Жасаалтад орсон 310 тээврийн хэрэгслийн эзэмшигч бүрийг бүрэн хамруулах, байршил дээр нь үзэж шалгах, тээврийн хэрэгслийн ерөнхий байдал, арал, хөдөлгүүрийн мэдээллийг холбогдох аппликейшинд заасан үзүүлэлт бүрээр баталгаажуулан сан үүсгэх	4/05-5/20	Тоологч нар
5.	Харьяа нутаг дэвсгэртээ байгаа хасагдах тээврийн хэрэгслийн бүртгэлийг шинэчлэн гаргаж бүртгэлээс хасуулах тээврийн хэрэгслийн эзэмшигч бүрээс хүсэлтийг хүлээн авах	4/05-5/20	Тоологч нар
6.	Тооллогод хамрагдсан тээврийн хэрэгслийн мэдээг өдөр бүр нэгтгэж, авто тээврийн газарт хүргүүлэх	Өдөр бүр	Татварын Улсын байцаагч, Багийн Засаг дарга нар
7.	Гэмт хэрэг зөрчлийн улмаас журамлагдсан тээврийн хэрэгслүүдийг шинэчилсэн бүртгэл үзлэг тооллогод хамруулах	Тухай бүр	Цагдаагийн хэсэг
8.	Засгийн газрын 2022 оны 47 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт ороогүй, АТБӨЯХ-ийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, зам ашигласны төлбөрөө төлөөгүй тохиолдолд авто замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх арга хэмжээг авч, хяналт тавьж ажиллах	Тухай бүр	Цагдаагийн хэсэг
9.	Төрийн байгууллагад бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийг шинэчилсэн бүртгэл үзлэг, тооллогод бүрэн хамруулах	4/05-5/20	Байгууллагын дарга эрхлэгч, нягтлан бодогч нар

1	2	3	4
10	Төрийн болон орон нутгийн өмчийн газрын шийдвэрээр шилжилт хөдөлгөөн болон хасалт хийгдээгүйгээс болж татварын өр үүсэж тухайн өмчлөгч дээрээ бүртгэлтэй байгаа тээврийн хэрэгслүүдийн баримт бичгийг бүрдүүлж бүртгэлээс хасуулах, шилжүүлэх, үүссэн өр төлбөрийг барагдуулах	4/05-5/20	Байгууллагын дарга эрхлэгч, нягтлан бодогч нар

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:  
 ТАТВАРЫН УЛСЫН БАЙЦААГЧ *М.Саруулбуян* М.САРУУЛБУЯН